



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны
тайлангийн талаарх төлөөлөн удирдах
зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. 2025 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЯДАМЖАВ



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн
талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

2. 2025 онд компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангах, 2024 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.ЯДАМЖАВ





**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**“Багануур” ХК-ийн дүрэмд өөрчлөлт
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” ХК-ийн дүрэмд дор дурдсан өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад “гишүүд” гэснийг “дарга” гэж өөрчлөх;

1.2. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад “бүтцийн нэгжийн” гэснийг “газар, хэлтсийн” гэж өөрчлөх;

1.3. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.2 дах заалтад “12 (арван хоёр)” гэснийг “13 (арван гурав)” гэж өөрчлөх;

2. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ЯДАМЖАВ



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 07, 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсон хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх ердийн гишүүдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, хараат бус гишүүдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг эрх бүхий байгууллагаас хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болох нь тогтоогдсон өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Д.ЯДАМЖАВ



"Багануур" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн

04 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



"Багануур" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа
эзэмшигчдийг төлөөлөх ердийн гишүүдийн нэрс

Ердийн гишүүдийн нэрс:

1. П.Баттер
2. И.Лувсанцэрэн
3. Э.Түвшин
4. Г.Намчинсүрэн
5. Ч.Дондогмаа
6. Б.Гэрлээ
7. М.Отгонбаяр
8. Э.Шижир

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн

04 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт



“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүдийн нэрс

Хараат бус ишүүдийн нэрс:

1. Д.Энхжаргал
2. Н.Зоригтсайхан
3. Ө.Гэрэлт-Од
4. С.Цолмон
5. Б.Даваатогтох